



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ХОРОО

ГЭР БҮЛИЙН СТАТИСТИКИЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА-2018



Улаанбаатар хот

2019 он

Санал, хүсэлт байвал доорх хаягаар холбоо барина уу.

Үндэсний статистикийн хороо
Засгийн газрын III байр
Бага тойруу-44, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар-11, Монгол Улс
Утас: (976-51)-264554
Факс: (976-11)-324518
Веб хуудас: www.nso.mn, www.1212.mn

АГУУЛГА	
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
УДИРТГАЛ	4
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	5
1.1 Хүн ам.....	5
1.2 Өрх.....	8
1.3 Гэрлэлт	11
1.4 Цуцлалт	14
1.5 Үрчлэлт	14
1.6 Нийгмийн хамгаалал.....	15
1.7 Боловсрол	16
1.8 Хөдөлмөр эрхлэлт	18
1.9 Эрүүл мэнд.....	19
1.10 Гэр бүлийн хүчирхийлэл.....	21

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮСХ	Үндэсний статистикийн хороо
НҮТС	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа
ӨНЭЗС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
АХС	Ажиллах хүчний судалгаа
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
НЗҮ	Нийгмийн зарим үзүүлэлт

УДИРТГАЛ

Гэр бүлийн статистикийн ангилал, аргачлал

“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.4.2-т гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, бат бөх хариуцлагатай гэр бүлийг дэмжин, хүчирхийллийг бууруулах, хүчирхийлэлд өртөгчдийг хамгаалах, гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх эрх зүйн таатай орчинг бүрдүүлэхээр тусгагдсан.

Гэр бүлийн статистикийн нэгдсэн үзүүлэлтийг тооцох аргачлалын зорилго нь гэр бүлийн статистикийн үзүүлэлтийн тооцох арга зүйг олон улсын нийтлэг арга зүйтэй нийцрүүлэх, үзүүлэлтийн нэгдсэн систем бий болгох, бүх түвшний хэрэглэгчдийг нэгдсэн ойлголт, тодорхойлолт, арга зүйгээр хангахад оршино.

Энэхүү аргачлал нь хүний хөгжлийн анхдагч орчин болсон гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах тогтолцоог үндэсний хэмжээнд бэхжүүлэх, гэр бүлийн гишүүдийн эрхийг баталгаажуулах чиглэлээр эрх зүйн болон бодлого, хөтөлбөрийн суурь мэдээлэл болгон ашиглагдана.

Уг аргачлалд орсон нийт 146 үзүүлэлтийн 56 үзүүлэлт нь Үндэсний Статистикийн хороо (ҮСХ)-ноос батлагдсан аргачлалд багтсан болно.

Тус аргачлал нь дараах 11 бүлгийн 146 үзүүлэлтээс бүрдэнэ.


Үүнд:

1. Хүн ам
2. Өрх
3. Гэрлэлт
4. Цуцлалт
5. Үрчлэлт
6. Нийгмийн хамгаалал
7. Идэвх, оролцоо
8. Боловсрол
9. Хөдөлмөр эрхлэлт
10. Эрүүл мэнд
11. Гэр бүлийн хүчирхийлэл

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.1 Хүн ам

Зураг 1 Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, төрлөөр




Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 2018 онд 105.7 мянга болж, өмнөх оноос 2100 (2.0%) аар, 2008 онтой харьцуулахад 29.4 (38.4%) мянгаар өссөн байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэний 43.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний 44.4 хувь нь төрөлхийн, 55.6 хувь нь олдмол, үүнээс 76.4 хувь нь ердийн өвчнөөс, 7.1 хувь нь мэргэжлээс шалтгаалах өвчнөөс, 4.4 хувь нь зам тээврийн ослоос, 9.7 хувь нь ахуйн ослоос, 2.4 хувь нь үйлдвэрлэлийн ослын шалтгаантай байна.

Хүснэгт 1 Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, төрөл, жилээр

	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Нийт	76 369	80 796	82 631	86 865	92 263	96 325	99 573	101 730	100 993	103 630	105 730
Төрөлхийн	25 140	26 708	27 278	28 268	30 346	34 239	35 681	41 550	43 082	44 384	46 965
Олдмол	51 229	54 088	55 353	58 597	61 917	62 086	63 892	60 180	57 911	59 246	58 765

Зураг 2 Хөгжлийн бэрхшээлтэй хүн, төрлөөр, 2018 он



Хөгжлийн бэрхшээлтэй иргэний 21.6 (20.4%) мянга нь хөдөлгөөний, 20.4 (19.3%) мянга нь сэтгэцийн, 11.5 (10.9%) мянга нь харах эрхтний, 8.4 (8.0%) мянга нь сонсголын, 7.3 (6.9%) мянга нь хавсарсан, 4.3 (4.1%) мянга нь ярианы, 32.2 (30.4%) мянга нь хөгжлийн бусад хэлбэрийн бэрхшээлтэй байна.


Хүснэгт 2 Эцэг, эх нь гадаадад амьдардаг хүүхэд /0-17 насны хүүхдийн хувь, эцэг, эх нь өөр улсад амьдардаг эсэхээр, 2013 он/

	0-17 насны хүүхдийн хувь					Эцэг, эх нь гадаадад амьдардаг 0-17 насны хүүхдийн хувь	0-17 насны хүүхдийн тоо
	Эцэг, эх нь гадаадад амьдардаг			Эцэг, эх нь гадаадад амьдардаггүй	Бүгд		
	Эх нь гадаадад амьдардаг	Эцэг нь гадаадад амьдардаг	Хоёулаа гадаадад амьдардаг				
Дүн	0.4	0.8	0.4	98.5	100.0	1.5	18 114
Хүйс							
Эрэгтэй	0.3	0.9	0.3	98.4	100.0	1.6	9 233
Эмэгтэй	0.4	0.7	0.5	98.5	100.0	1.5	8 881
Нас							
0-4	0.6	1.7	0.8	96.9	100.0	3.1	6 851
5-9	0.4	0.6	0.3	98.7	100.0	1.3	4 090
10-14	0.3	0.4	0.1	99.2	100.0	0.8	2 183
15-17	0.0	0.0	0.0	100.0	100.0	0.0	4 989
Бүс							
Баруун	0.0	0.2	0.1	99.7	100.0	0.3	2 872
Хангай	0.1	0.2	0.1	99.5	100.0	0.5	3 892
Төв	0.4	0.4	0.2	98.9	100.0	1.1	3 071
Зүүн	0.2	0.3	0.0	99.4	100.0	0.6	1 428
Улаанбаатар	0.6	1.7	0.8	96.9	100.0	3.1	6 851
Өрхийн аж байдлын түвшин							
Доогуур	0.0	0.0	0.0	100.0	100.0	0.0	3 901
Дунджаас доогуур	0.1	0.2	0.1	99.5	100.0	0.5	3 878
Дундаж	0.4	0.6	0.2	98.9	100.0	1.1	3 606
Дунджаас дээгүүр	0.5	1.0	0.5	98.0	100.0	2.0	3 324
Дээгүүр	0.9	2.4	1.2	95.5	100.0	4.5	3 404

2013 оны НҮТС-д эцэг, эхийнх нь хэн нэгэн эсвэл хоёулаа гадаадад амьдарч байгаа хүүхдийн талаар судалсан байдаг. Судалгаанаас тооцсон эцэг, эх нь гадаадад амьдардаг хүүхдийн хувийг харахад 0-17 насны нийт хүүхдийн 1.5 хувийнх нь эцэг,

эхийн хэн нэг нь эсвэл хоёулаа гадаадад амьдардаг байна. Эцэг, эх нь гадаадад амьдардаг хүүхдийн хувь хүн ам зүй шинж байдлаар төдийлөн ялгаагүй байна. Бүсээр авч үзвэл эцэг, эх нь гадаадад амьдардаг хүүхдийн хувь Улаанбаатар хотод (3.1 хувь), дээгүүр аж байдалтай өрхийн хувь (4.5 хувь) бусадтайгаа харьцуулахад харьцангуй өндөр байсан байна.

Зураг 3 Өрх толгойлсон эцэг/эхийн тоо, жилээр



Өрх толгойлсон эх 2018 онд 72.0 мянга болж, өмнөх оноос 4.8 мянга (6.3%)-аар буурсан бол 2008 онтой харьцуулахад 4.7 (6.2%) мянган хүнээр өсжээ. Өрх толгойлсон эцгийн тоо 2018 онд 19.5 мянга болж өмнөх оноос 1.1 мянга (5.5%)-аар буурсан бол 2008 онтой харьцуулахад 3.1 мянга (13.8%)-аар буурчээ.


Хүснэгт 3 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эхийн тоо

	2008*	2009*	2010*	2011*	2012*	2013	2014	2015	2016	2017	2018
БҮГД	42 474	42 327	39 937	38 677	38 559	39 904	40 433	39 320	38 147	38 148	36 271
Баруун бүс	4 588	4 835	4 112	3 954	3 954	4 797	4 995	4 815	4 611	4 727	4 759
Хангайн бүс	9 536	9 780	9 233	9 146	9 251	10 179	10 540	10 284	10 194	10 760	10 064
Төвийн бүс	9 573	8 930	8 058	7 890	8 263	7 979	8 085	8 195	7 806	7 573	7 600
Зүүн бүс	4 058	3 781	3 993	3 693	3 589	3 924	3 955	3 534	3 857	3 794	3 443
Улаанбаатар	14 719	15 001	14 541	13 994	13 502	13 025	12 858	12 492	11 679	11 294	10 405

* 16 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх

18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эхийн тоо 2018 онд 36.3 мянга болж, өмнөх оноос 1.9 мянга (4.9%)-аар буурсан бол 2008 онтой харьцуулахад 6.2 (14.6%) мянгаар буурсан байна. Хангайн бүс болон Улаанбаатарт 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойсон эхийн тоо бусад бүстэй харьцуулахад их байна. Сүүлийн 5 жилийн динамикаас харахад эхийн тоо буурч байна.


Зураг 4 Ихэр хүүхэдтэй өрхийн тоо, 2016-2018 он



Улсын хэмжээнд 2018 онд ихэр хүүхэдтэй өрхийн тоо 9.2 мянга болж, өмнөх оноос 684 (8.1%)-өөр өссөн байна. Ихэр хүүхэдтэй өрхийн тоог 3 жилийн өмнөхтэй харьцуулахад даруй 536 (15.2%) -аар өсжээ. Ихэр хүүхэдтэй өрхийг хүүхдийн тоогоор авч үзвэл 2 ихэр хүүхэдтэй өрх 9059, 3 ихэр хүүхэдтэй өрх 113, 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх 2 байна.

1.2 Өрх

Зураг 5 18 хүртэлх насны 4 болон түүнээс дээш насны хүүхэдтэй өрхийн тоо, мянган өрх




*16 хүртэлх насны 4 болон түүнээс дээш насны хүүхэдтэй өрхийн тоо

18 хүртэлх насны 4, түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо 2018 онд 45.3 мянга болж, өмнөх оноос 9.1 мянган (25.1%) өрхөөр, 2008 онтой харьцуулахад 13.4 мянган (42.1%) өрхөөр тус тус буурчээ. Сүүлийн 10 жилийн динамикаас харахад 18 хүртэлх насны 4,


түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо 2012 онд хамгийн цөөн буюу 23.5 мянга, 2018 онд хамгийн их буюу 50.3 мянга байна.

Өрх үүсгэн ганц биеэр амьдардаг өндөр настай хүний тоо



Ганц биеэрээ амьдарч буй өндөр настай хүний тоо 2018 онд 39.6 мянга болж, өмнөх оноос 1.7 (4.6%) мянгаар өссөний 29.3 (73.9%) мянга нь 55, түүнээс дээш насны эмэгтэй, 10.3 (26.1%) мянга нь 60, түүнээс дээш насны эрэгтэйчүүд байна. Ганц биеэрээ амьдарч буй өндөр настай хүмүүсийн тоог 6 жилийн өмнөхтэй харьцуулахад даруй 12.0 (43.4%) мянгаар өсжээ.

Зураг 6 Нэг өрхийн сарын дундаж орлого, хот, хөдөөгөөр




Нэг өрхийн сарын дундаж орлого улсын дунджаар 2017 онд 1.0 сая төгрөг болж, 2016 оныхоос 91.4 (9.7%) мянган төгрөгөөр нэмэгджээ. 2017 онд хотод нэг өрхийн сарын дундаж орлого өмнөх оноос 110.8 (11.0%) мянган төгрөг, хөдөөд 69.6 (8.5%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Хот, хөдөөгийн орлогыг хооронд нь харьцуулбал, 2017 онд хотын нэг өрхийн сарын дундаж орлого хөдөөгийнхөөс 232.0 (26.2%) мянган төгрөгөөр илүү байна. Энэ нь өмнөх оноос 41.2 мянган төгрөг буюу 2.8 пунктээр өссөн байна.

Нэг өрхийн сарын дундаж орлогыг бүсээр өмнөх онтой харьцуулбал, 2017 онд Баруун бүсэд 116.9 (13.8%) мянган төгрөг, Хангайн бүсэд 71.9 (9.1%) мянган төгрөг, Төвийн

бүсэд 82.3 (8.9%) мянган төгрөг, Улаанбаатар хотод 115.8 (10.8%) мянган төгрөгөөр нэмэгдэж, харин Зүүн бүсэд 3.8 (0.5%) мянган төгрөгөөр буурсан байна.


Зураг 7 Нэг өрхийн сарын дундаж зарлага, хот, хөдөөгөөр



2017 оны дүнгээр өрхийн сарын дундаж зарлага улсын дунджаар 1.1 сая төгрөг болж, 2016 оныхоос 126.2 (13.1%) мянган төгрөгөөр өссөн байна. Нэг өрхийн сарын дундаж зарлагыг хот, хөдөөгөөр авч үзвэл, 2017 онд хотод нэг өрхийн сарын дундаж зарлага өмнөх оноос 146.9 (14.6%) мянган төгрөг, хөдөөд 96.7 (10.9%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Хот, хөдөөгийн зарлагыг хооронд нь харьцуулбал, 2017 онд хотын нэг өрхийн сарын дундаж зарлага хөдөөгийнхөөс 164.4 (16.7%) мянган төгрөгөөр илүү буюу энэ нь өмнөх оноос 50.1 мянган төгрөг буюу 3.9 пунктээр өссөн байна.

Бүсээр нэг өрхийн сарын дундаж зарлагыг өмнөх онтой харьцуулбал, 2017 онд баруун бүсэд 175.6 (18.5%) мянган төгрөг, хангайн бүсэд 98.8 (11.6%) мянган төгрөг, төвийн бүсэд 95.0 (9.6%) мянган төгрөг, зүүн бүсэд 41.8 (5.0%) мянган төгрөг, Улаанбаатар хотод 153.9 (14.9%) мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Зураг 8 Зээлтэй өрхийн эзлэх хувь



Монгол Улсын нийт өрхийн 48.0 хувь нь 2016 онд ямар нэгэн зээлтэй байсан бол 2017 оны байдлаар нийт өрхийн 52.1 хувь нь буюу 461.4 мянган өрх зээлтэй амьдарч байна. Үүнээс: нийт өрхийн 20.8 хувь нь буюу 184.2 мянган өрх цалингийн зээлтэй, 12.4 хувь

нь буюу 109.8 мянган өрх тэтгэврийн зээлтэй, 8.2 хувь нь буюу 72.6 мянган өрх малчны зээлтэй, 6.5 хувь нь буюу 57.6 мянган өрх орон сууцны зээлтэй байна.


Хүснэгт 4 Ядуурлын хамралтын хүрээ

Суурьшил	2008	2009	2010	2011	2012	2014	2016
Улсын дундаж	35.2	38.7	38.8	33.7	27.4	21.6	29.6
Хот	26.9	30.6	33.2	28.7	23.3	18.8	27.1
Хөдөө	46.6	49.6	49.	43.2	35.4	26.4	34.9
Бүс							
Баруун бүс	47.1	48.7	52.7	40.5	32.3	26.0	36.0
Хангайн бүс	46.6	55.2	51.9	49.1	38.5	25.3	33.6
Төвийн бүс	30.7	29.3	29.9	28.1	28.2	22.2	26.8
Зүүн бүс	46.7	43.8	42.3	40.	33.4	31.4	43.9
Улаанбаатар	21.9	26.7	31.2	25.8	19.9	16.4	24.8

Ядуурлын хамралтын хүрээ буюу ядуурлын түвшин нь нийт хүн амд ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын эзлэх хувийг харуулна. 2016 онд улсын дундаж 29.6 хувь байсан ба зүүн бүст хамгийн их буюу 43.9 хувь байсан байна.


1.3 Гэрлэлт

Гэрлэлтээ сэргээсэн хүн



Гэрлэлтээ сэргээсэн хүнийг насны бүлгээр авч үзвэл эрэгтэйчүүд 30-34 насандаа, эмэгтэйчүүд 50-аас дээш насандаа хамгийн их гэрлэлтээ сэргээсэн байна. Тухайлбал, 2018 оны байдлаар харахад нийт 66 эмэгтэй, 64 эрэгтэй гэрлэлтээ сэргээсэн байна.

Зураг 9 Гэрлэлтээ сэргээсэн хүн, гэрлэлтийн дарааллаар, 2018 он



2018 онд гэрлэлтээ сэргээсэн хүмүүсийг хэд дэх гэрлэлт байсан эсэхээр харвал 2 дох гэрлэлтээ сэргээсэн хүмүүс хамгийн өндөр байгаа ба эрэгтэй 43, эмэгтэй 47 байна. Улаанбаатар хотод гэрлэлтээ сэргээсэн хүний тоо хөдөө, орон нутагтай харьцуулахад их буюу 51 байна.

Хүснэгт 5 15 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн эмэгтэйчүүдийн хувь, 2013 он

	15-49 насны эмэгтэй		20-49 насны эмэгтэй		
	15 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн хувь	15-49 насны эмэгтэйчүүдийн тоо	15 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн хувь	18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн хувь	20-49 насны эмэгтэйчүүдийн тоо
Дүн	0.4	12 830	0.4	6.2	11 235
Бүс					
Баруун	0.2	1 587	0.2	3.2	1 365
Хангай	0.3	2 557	0.3	6.5	2 258
Төв	0.5	2 063	0.5	10.1	1 867
Зүүн	0.2	926	0.2	7.0	824
Улаанбаатар	0.4	5 696	0.4	5.2	4 922
Нас					
15-19	0.3	1 595	na*	na*	na*
20-24	0.1	1 765	0.1	5.2	1 765
25-29	0.3	2 012	0.3	5.2	2 012
30-34	0.4	2 002	0.4	7.0	2 002
35-39	0.5	2 010	0.5	7.5	2 010
40-44	0.3	1 816	0.3	5.7	1 816
45-49	0.7	1 631	0.7	6.2	1 631

*na-утга тооцоогүй

Нөхөн үржихүйн насны нийт эмэгтэйчүүдийн хувьд 15 наснаас өмнө гэрлэсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь харьцангуй бага (харгалзан 0.2 болон 0.4 хувь) боловч боловсролын түвшний ялгаатай байдал харагдаж байна. Арван таван нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь бага боловч 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн 20-49 насны эмэгтэйчүүдийн хувь харьцангуй өндөр (6.2 хувь) байна. 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн эмэгтэйчүүдийн хувийг бүсээр авч үзвэл Баруун бүс болон Улаанбаатар хотод (3.2-5.2 хувь) бусад бүстэй (6.5-10.1 хувь) харьцуулахад хамгийн бага байжээ. 15 ба 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн хувийг насны бүлгээр авч үзэх нь

эрт гэрлэлтийн ерөнхий хандлагыг харахад хэрэгтэй байдаг. 15 ба 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувийг насны бүлгээр үзвэл харьцангуй бага, ижил түвшинд байна.

Хүснэгт 6 Насны зөрүүтэй гэрлэсэн болон хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн тоо, 2013 он


	15-19 насны гэрлэсэн/хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн тоо	20-24 насны гэрлэсэн/хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн тоо
Дүн	78	890
Бүс		
Баруун	5	86
Хангай	16	159
Төв	14	176
Зүүн	9	57
Улаанбаатар	34	411
Боловсрол		
Боловсролгүй	3	38
Бага	0	25
Суурь	7	89
Бүрэн дунд	51	298
Техникийн болон тусгай мэргэжлийн дунд	13	98
Дээд	3	342

Эрт гэрлэлтийг тодорхойлдог өөр нэг үзүүлэлт нь хосуудын насны зөрүү ба үүнийг өөрөөсөө 10 ба түүнээс олон насаар ах хүнтэй гэрлэсэн эсвэл гэр бүлийн харилцаанд орсон эмэгтэйчүүдийн хувиар илэрхийлдэг. 2013 оны судалгааны дүнгээс харахад Улаанбаатар хот, Хангай болон Төвийн бүсийн нутагт 15-19 насны гэрлэсэн/хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн тоо бусад бүстэй харьцуулахад их байна. Харин 20-24 насны гэрлэсэн/хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн тоог боловсролын түвшнээр авч үзвэл бүрэн дунд боловсролтой эмэгтэйчүүд бусад түвшинтэй харьцуулахад их байсан байна.

Түүнчлэн Монгол Улсад 15-19 насны гэрлэсэн/ хамтран амьдрагчтай нийт эмэгтэйчүүдийн 3.4 хувь нь өөрөөсөө 10 ба түүнээс дээш насаар ах, 20.0 хувь нь 5-9 насаар ах эрэгтэйтэй гэр бүл болжээ. Харин эдгээр үзүүлэлт 20-24 насны гэрлэсэн эмэгтэйчүүдийн хувьд харьцангуй бага (3.0 хувь, 12.7 хувь) байдаг байна. Тухайлбал, бага боловсролтой 20-24 насны эмэгтэйчүүдийн 10.5 хувь нь өөрөөсөө 10 ба түүнээс олон насаар ах нөхөр/ хамтран амьдрагчтай байгаа нь улсын дундаж 3.0 хувиас эсрэг дүр зурагтай байна. Өрхийн аж байдлын түвшнээр авч үзвэл дээгүүр түвшний аж байдалтай өрхийн эмэгтэйчүүдийн хувьд дээрх үзүүлэлт өндөр байжээ. *(Нарийвчилсан тоог НҮТС-ны 2013 оны тайлангаас харна уу.)*

1.4 Цуцлалт

Зураг 10 Цуцлалтын тоо /гэр бүл байсан хугацаагаар/



Гэр бүл цуцлалтыг гэр бүл болон хамтран амьдарч байсан хугацаагаар нь авч үзэхэд 4-6 жил амьдарч байгаад гэр бүл цуцалсан хосуудын эзлэх хувь сүүлийн жилүүдэд нэмэгдэж байснаа 2013 оноос буурсан байна. Харин 10, түүнээс дээш жилийн хугацаанд гэр бүл болон амьдарч байсан хүмүүсийн эзлэх хувь 2008 оноос хойш буурах хандлагатай байсан боловч 2015 оноос өсч 2018 онд 62.1 хувь болж өмнөх оноос 3.5 пунктээр өсжээ. Гэр бүл цуцлалтыг сүүлийн 10 жилийн байдлаар авч үзэхэд 2008 онд хамгийн бага буюу 1901 байсан бол 2018 онд хамгийн их буюу 4201-д хүрсэн байна.

1.5 Үрчлэлт

Хүснэгт 7 Үрчлэгдсэн хүүхдийн тоо, насны бүлгээр, 2018 он

Аймаг, нийслэл, сум, дүүрэг	Бүгд	Хүүхдийн насны бүлэг			
		3 нас хүртэл	3-6	7-9	10 ба дээш
Бүгд	1 549	704	402	142	301
Архангай	51	37	9	3	2
Баян-Өлгий	110	54	50	3	3
Баянхонгор	50	24	19	3	4
Булган	40	17	16	2	5
Говь-Алтай	22	11	7	2	2
Говьсүмбэр	9	4	1	2	2
Дархан-Уул	30	15	4	3	8
Дорноговь	19	9	7	2	1
Дорнод	37	24	6	2	5
Дундговь	9	5	1	0	3
Завхан	20	15	3	1	1
Орхон	56	23	13	6	14
Өвөрхангай	54	35	11	3	5
Өмнөговь	16	4	3	5	4
Сүхбаатар	28	16	4	3	5
Сэлэнгэ	54	29	15	5	5
Төв	39	15	12	4	8
Увс	46	23	11	7	5
Улаанбаатар	669	226	169	70	204

Ховд	58	35	15	4	4
Хөвсгөл	104	63	22	10	9
Хэнтий	28	20	4	2	2

2018 онд 1549 хүүхэд үрчлэгдсэний 704 (45.4 хувь) нь 3 хүртэлх насны, 402 (26.0 хувь) нь 3-6 насны, 142 (9.2 хувь) нь 7-9 насны, үлдсэн 301 (19.4 хувь) нь 10 ба түүнээс дээш насны хүүхдүүд байна. Үрчлэгдсэн хүүхдийн тоог сүүлийн 10 жилийн динамикаас үзвэл 3 хүртэлх насны хүүхдийн үрчлэлт 2008 онд 39.0 хувь байсан бол 2018 онд 45.4 хувь болж 6.4 пунктээр нэмэгдэж, 7-9 насны хүүхдийнх 2008 онд 13.8 хувиас 2018 онд 9.2 болж 4.6 пунктээр буурчээ.

1.6 Нийгмийн хамгаалал

Хүснэгт 8 Тэтгэвэр, тэтгэмж тогтоогдоогүй ахмад настай хүний тоо

Аймаг, нийслэл	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
БҮГД	783	842	1 173	1 148	1 076	1 432	772	1 346	433	532	2 522
Баруун бүс	71	98	319	162	102	152	52	310	52	69	418
Баян-Өлгий	46	36	39	38	62	31	21	13	1	22	93
Говь-Алтай	4	5	13	3	3	4	8	11	9	3	131
Завхан	10	17	24	26	2	43	3	12	3	1	28
Увс	4	15	181	42	25	39	-	247	-	16	32
Ховд	7	25	62	53	10	35	20	27	39	27	134
Хангайн бүс	145	180	175	133	152	126	75	232	45	54	733
Архангай	31	21	41	21	12	11	8	6	11	10	186
Баянхонгор	5	36	26	18	23	48	20	10	4	22	36
Булган	12	13	20	8	21	9	16	1	-	-	384
Өвөрхангай	28	16	13	12	27	5	16	12	14	14	33
Хөвсгөл	48	77	51	51	50	37	10	193	4	-	86
Орхон	21	17	24	23	19	16	5	10	12	8	8
Төвийн бүс	146	151	200	255	202	245	133	78	131	77	849
Дорноговь	7	33	22	13	30	12	4	6	3	5	20
Дундговь	10	10	14	17	9	19	24	2	5	3	7
Өмнөговь	11	20	22	18	13	6	15	6	3	-	-
Сэлэнгэ	57	36	36	57	58	55	46	10	65	27	350
Төв	38	24	32	28	35	87	29	1	25	20	466
Дархан-Уул	22	24	73	120	54	63	15	51	30	22	6
Говьсүмбэр	1	4	1	2	3	3	-	2	-	-	-
Зүүн бүс	76	72	93	93	112	197	72	712	78	141	249
Дорнод	13	10	20	21	37	50	47	14	-	-	8
Сүхбаатар	14	6	25	13	6	41	7	25	1	6	1
Хэнтий	49	56	48	59	69	106	18	673	77	135	240
Улаанбаатар	345	341	386	505	508	712	440	14	127	191	273

2018 онд тэтгэвэр, тэтгэмж тогтоогдоогүй ахмад настай хүний тоо 2.5 мянга болж өмнөх оноос 2.0 мянгаар өсжээ. Тэтгэвэр, тэтгэмж тогтоогдоогүй ахмад настай хүний тоо сүүлийн 10 жилийн байдлаар авч үзэхэд 2016 онд хамгийн бага буюу 433 байсан бол 2018 онд хамгийн их буюу 2522-д хүрсэн байна.

Хүснэгт 9 Нийгмийн хамгааллын зарим үзүүлэлтүүд

	2019		
	1 сар	2 сар	3 сар
Гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрхийн тоо	31	56	124
Хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүний тоо	12	26	51
Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, дөрөв ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг, эхийн тоо	1	1	5

Дээрх үзүүлэлтүүдийг 2019 оноос эхлэн тооцож эхэлдэг болсон учир 2019 оны эхний 3 сарын байдлаарх үзүүлэлтийг оруулсан болно. Гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрхийн тоог эхний 2 сартай харьцуулахад өссөн ба 124 болжээ. Харин хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүний тоо 3-р сарын байдлаар өсч 51 болсон бол нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, дөрөв ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг, эхийн тоо 5 байна.


1.7 Боловсрол

Хүснэгт 10 Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, насны бүлгээр, хүйсээр

	2013-2014		2014-2015		2015-2016		2016-2017		2017-2018		2018-2019	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
	1368	614	1437	609	1369	552	1513	616	1597	665	1087	428
Насны бүлгээр												
2 хүртэлх	16	6	47	19	30	13	21	7	23	13	20	7
2	145	67	165	85	163	68	191	91	179	72	95	49
3	248	98	312	137	271	112	302	116	341	141	219	87
4	392	185	375	125	376	146	399	171	409	164	308	126
5	452	207	468	210	424	164	501	202	491	215	328	114
6	115	51	70	33	105	49	99	29	154	60	117	45


Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо сүүлийн 6 жилийн байдлаар авч үзэхэд 2018-2019 оны хичээлийн жилд хамгийн бага буюу 1087 байсан ба үүнээс 428 нь эмэгтэй хүүхдүүд байсан бол 2017-2018 оны хичээлийн жилд хамгийн их буюу 1597-д хүрсэн байна. Энэ үзүүлэлтийг насны бүлгээр авч үзвэл 2018 онд СӨБ-д хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй нийт хүүхдийн 30.2 хувь нь 5 настай хүүхдүүд эзэлж байна.

Зураг 11 ЕБС-д хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, хүйсээр



Ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо сүүлийн 6 жилийн байдлаар авч үзэхэд 2018-2019 оны хичээлийн жилд хамгийн бага буюу 6518 байсан ба үүнээс 2948 нь эмэгтэй хүүхдүүд байсан бол 2013-2014 оны хичээлийн жилд хамгийн их буюу 11.2 мянгад хүрсэн байна. 2018 онд ЕБС-д хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй нийт хүүхдийн 47.7 хувь нь Улаанбаатар хотод, 7.8 хувь нь Хөвсгөл аймагт суралцаж байна.

Зураг 12 ЕБС-ийн дотуур байранд хамрагдалт




Аймаг, нийслэл төдийгүй хөдөө, орон нутагт сурагчдын дотуур байрны асуудал жил бүр тулгамдаж байгаа бөгөөд дотуур байранд хамрагдахаар хүсэлт гаргаад

хамрагдсан байдлыг 2018 оны байдлаар авч үзвэл 90.7 хувь нь хамрагдаж чадсан байна.


1.8 Хөдөлмөр эрхлэлт

Зураг 13 Ажилтай иргэнтэй өрхийн тоо, ам бүлийн тоогоор



2018 оны АХС-ны дүнгээр ажил эрхэлдэг иргэнтэй өрхийн тоо 749.5 мянга болж өмнөх оноос 2.8 мянга (0.4%)-аар өсжээ. Ажил эрхэлдэг иргэнтэй өрхийг ам бүлээр нь авч үзвэл 4 гишүүнтэй өрхөд ажил эрхэлдэг 1 хүнтэй өрх 36.7 хувь, 2 хүнтэй өрх 54.2 хувь, 3 хүнтэй өрх 7.6 хувь, 4 түүнээс дээш ажил эрхэлдэг хүнтэй өрх 1.4 хувийг тус тус эзэлж байна. Өөрөөр хэлбэл Улсын хэмжээнд өрхөд ажил эрхэлдэг 1-2 хүнтэй өрх 91.0 хувийг эзэлж байна. Харин ажилгүй иргэнтэй өрхийг ам бүлээр нь авч үзвэл 4 гишүүнтэй өрхөд ажил эрхэлдэггүй 1 хүнтэй өрх 91.2 хувь, 2 хүнтэй өрх 8.1 хувь, 3 хүнтэй өрх 0.6 хувь, 4 түүнээс дээш ажил эрхэлдэггүй хүнтэй өрх 0.1 хувийг тус тус эзэлж байна. 2016 онд ажилтай иргэнтэй өрхийн тоо 690.4 мянга байсан бол 2018 онд 8.5 хувиар өссөн байна.

Зураг 14 Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хүйсээр



Энэхүү үзүүлэлт нь хөдөлмөрийн насны хүн амд эзлэх ажиллагчдыг илэрхийлэх бөгөөд 2018 онд эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 63.7 хувь байгаа бол эмэгтэйчүүдийнх 49.6 хувь байна. Энэ нь эмэгтэй ажиллагчдын тоо бага байгааг

илэрхийлж байна. Сүүлийн 5 жилийн динамикаас харахад 2018 онд энэ үзүүлэлт хамгийн бага байгаа бол 2014 онд 52.1 хувь байна.


1.9 Эрүүл мэнд

Хүснэгт 11 Төлөвлөсөн төрөлтийн тоо

	Төрөлтөө төлөвлөсөн байдал			Дүн	Судалгааны өмнөх 2 жилийн хугацааны төрөлтийн тоо
	Хүсэж байсан	Арай хожуу	Хүсээгүй		
Бүгд	80.9	12.5	6.6	100.0	3 006
Төрөлтийн дараалал					
1	79.0	14.8	6.2	100.0	888
2	82.1	13.2	4.7	100.0	960
3	84.0	10.2	5.8	100.0	714
4+	77.1	10.2	12.7	100.0	444
Эхийн хүүхдээ төрүүлэх үеийн нас					
15-19	70.4	21.3	8.3	100.0	145
20-24	77.3	16.3	6.4	100.0	820
25-29	80.6	13.2	6.3	100.0	857
30-34	85.3	8.8	5.9	100.0	590
35-39	84.4	6.7	8.8	100.0	314
40+	75.7	6.8	17.6	100.0	85


2013 оны НҮТС-ны өмнөх 2 жилийн хугацаанд хүүхэд төрүүлсэн болон судалгааны үед жирэмсэн байгаа 15-49 насны эмэгтэйчүүдийн 80.9 хувь нь жирэмслэлтээ төлөвлөсөн байжээ. Харин 12.5 хувь нь арай хожуу жирэмслэх бодолтой байсан бол үлдсэн 6.6 хувь нь огт төлөвлөөгүй жирэмслэлт байжээ 2-3 хүүхэдтэй эмэгтэйчүүдийн дунд хүсээгүй төрөлт/ жирэмслэлт хамгийн бага (харгалзан 4.7, 5.8 хувь) бол 15-19, 35-39 болон 40 ба түүнээс дээш насныхны дунд хамгийн их (харгалзан 8.3, 8.8 болон 17.6 хувь) байна. Ялангуяа, өсвөр насны (15-19 нас) охидын 91.7 хувь жирэмслэлт, төрөлтөө төлөвлөсөн гэж хариулсан бол энэ үзүүлэлт нь нас ахих тутам нэмэгдэж (20-24 нас 93.6 хувь, 25-29 нас 93.8 хувь) байсныг харуулж байна.

Зураг 15 1000 амьд төрөлтөд ногдох нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин




Нялхсын эндэгдлийн түвшин сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байгаа ба 2000 онд 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин 32.8 хувь байсан бол 2018 онд 13.4 хувь болж 19.4 пунктээр буурсан байна. Харин 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 2000 онд 42.4 хувь байсан бол 2018 онд 16.9 хувь болж 25.5 пунктээр буурчээ.

Зураг 16 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин, 2018 он




Нялхсын эндэгдлийн түвшин 2018 оны байдлаар Баян-Өлгий, Говь-Алтай, Архангай, Булган, Төв аймагт улсын дунджаас 2.9-4.9 пунктээр их, Дундговь, Говьсүмбэр, Дорнод, Орхон 5.7-11.3 пунктээр бага байна.

Зураг 17 Үр хөндөлтийн тоо, 2000-2018 он



Улсын хэмжээнд 2016 онд нийт 18.3 мянган үр хөндөлт бүртгэгдсэн нь 10 жилийн өмнөхөөс 45.4 хувиар өсөж, өнгөрсөн оныхоос 9.7 хувиар буурсан байна. 2018 оны байдлаар нийт үр хөндөлтийн 70.0 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн 27.5 хувь нь хөдөө, орон нутагт ногдож байна.

Хүүхэд төрүүлэх хүсэлгүй гэрлэсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь




Гэрлэсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн 51.0 хувь нь хүүхэд төрүүлэх хүсэлгүй байгаа бөгөөд НҮЭМС-2008 судалгаатай харьцуулахад (55.2%) буурчээ. Гэхдээ хүүхэдгүй болон 1 хүүхэдтэй эмэгтэйчүүдийн дунд жирэмслэлтээ хязгаарлах бодолтой эмэгтэйчүүдийн хувь НҮЭМС-2008 судалгаатай харьцуулахад (хүүхэдгүй 6.1%, нэг хүүхэдтэй 10.6%) өссөн дүнтэй байна. Хөдөөгийн эмэгтэйчүүдийг хотынхтой харьцуулахад илүү ихээр төрөлтөө хязгаарлах буюу хүүхэд төрүүлэхгүй байх бодолтой байна. Ялангуяа, хүүхэдгүй хөдөөгийн эмэгтэйчүүдийн дунд энэ хандлага хотынхоос 2 дахин их байна. Эмэгтэйчүүдийн насны бүлгээр авч үзвэл төрөлтөө хязгаарлах хүсэл 20-24 насныхны дунд хамгийн бага (8.6%) байгаа бөгөөд нас ахих тутамд эрчимтэй нэмэгдэж байна. Тухайлбал, тусгай мэргэжлийн дунд боловсролтой эмэгтэйчүүдийн 70.5 хувь нь төрөлтөө хязгаарлах хүсэлтэй байхад, уг үзүүлэлт бүрэн дунд боловсролтой эмэгтэйчүүдийн дунд 50.5 хувь, дээд боловсролтой эмэгтэйчүүдийн дунд 38.4 хувь байлаа. Харин өрхийн аж байдлын түвшин сайжрахад төрөлтөө хязгаарлах хүсэлтэй гэрлэсэн эмэгтэйчүүдийн хувь нэмэгдэж байна.

1.10 Гэр бүлийн хүчирхийлэл

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон 10 хүн тутмын 7 нь бие махбодын хүчирхийлэлд өртсөн 2 нь хамгаалалтанд хамрагдсан 5 нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн эхнэр байна.


2018 онд улсын хэмжээгээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 210 гэмт хэрэг бүртгэгдсэний 188 (89.5%)-д нь хэрэг бүртгэлийн хэрэг нээж, 140 (67.7%)-д нь эрүүгийн хэрэг үүсгэжээ. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн 105 (50%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн нь өмнөх оноос 47 (30.9%)-гоор буурсан байна (Зураг 18). Улсын хэмжээгээр 2018 онд 210 гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 13 (5.8%)-аар буурсан байна.

Зураг 18 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, 2017-2018 он



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2018 онд 1069 болж, өмнөх оноос 217- гоор буурахад Улаанбаатар хот (168), Баян-Өлгий (20), Орхон(21), Хэнтий (19), Сүхбаатар (21) аймгуудад буурсан нь голлон нөлөөлөв. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн 1069 хэргийн 589 (55.1%) нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг дүүргүүдээс Баянзүрх (160), Сонгинохайрхан (118), Баянгол (85)-д хамгийн их бүртгэгджээ.

Зураг 19 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, 2018 он



Хүснэгт 12 “Гэр бүлийн тухай” хуулиар шийдвэрлэсэн хэрэг, 2011-2018 он

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Улсын дүн	4 449	3 878	4 276	4 207	4 539	4 674	4 566	4 763
Гэрлэлт цуцалсан	3 642	3 100	3 382	3 182	2 978	2 980	2 791	2 945
Эцэг тогтоосон	325	278	313	430	531	450	467	392
Эцэг, эх байх эрх хассан	7	4	6	21	37	17	24	11
Хүүхдийн тэтгэлэг гаргуулах	364	370	454	478	825	1 006	1 056	1 146
Гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчийн төгөлдөр бус гэж тооцох	9	11	11	32	59	47	50	64
Бусад	102	115	110	64	109	174	178	205

Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуулиар 2018 онд 4763 хэрэг шийдвэрлэгдсэний 2945 (61.8%) нь гэрлэлт цуцалсан, 392 (8.2%) нь эцэг тогтоосон, 1146 (24.1%) нь хүүхдийн тэтгэлэг гаргуулах, 11 (0.2%) нь эцэг, эх байх эрх хассан, 64 (1.3%) нь гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцсон, 205 (4.3%) нь бусад хэрэг байна. “Гэр бүлийн тухай” хуулийн дагуу анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг өмнөх оноос 197 (4.3%)-оор өсөхөд гэр бүл цуцлалт 154 (5.5%)-өөр өссөн нь голлон нөлөөлжээ.

2018 онд гэмт хэргээс хохирсон 33.6 мянган хүний 14.7 мянга (43.7%) нь эмэгтэйчүүд, 1688 (5.0%) нь хүүхэд, 5545 (16.5%) нь 25-29 насны хохирогч, 5650 (16.8%) нь 30-34 насны хохирогч, 4482 (13.4%) нь 35-39 насны хохирогч, 3815 (11.4%) нь 40-44 насны хохирогч байна.

Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуулиар 2018 онд 4763 хэрэг шийдвэрлэсний 2945 (61.8%) нь гэрлэлт цуцалсан, 392 (8.2%) нь эцэг тогтоосон, 1146 (24.1%) нь хүүхдийн тэтгэлэг гаргуулах, 11 (0.2%) нь эцэг, эх байх эрх хассан, 64 (1.3%) нь гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцсон, 205 (4.3%) нь бусад хэрэг байна. “Гэр бүлийн тухай” хуулийн дагуу анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэг өмнөх оноос 197 (4.3%)-оор өсөхөд гэр бүл цуцлалт 154 (5.5%)-өөр өссөн нь голлон нөлөөлжээ.